АРХАНГАЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2019 ОНЫ 12 ДУГААР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны мэдээлэл

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит долоодугаар хуралдааныг 2019 оны 12 дугаар сарын 02-ны өдөр хуралдуулж Орон нутгийн төсвийн урьд оны үлдэгдлийг хуваарилан, аймгийн 2019 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай, Аймгийн 2019 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, 2020 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөө батлах тухай, Аймгийн эдийн засаг нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт, 2020 онд дэвшүүлсэн зорилт, орон нутгийн 2020 оны төсвийн төслийн тухай, Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдээс 2019 онд хийсэн ажлын тайлан, Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн тухай, Орон нутгийн өмчийн 2020 онд хувьчлах үл хөдлөх хөрөнгийн жагсаалт батлах тухай, Цэргийн албыг дүйцүүлэн хаах иргэдийн тоог батлах тухай, Цэцэрлэг хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлах тухай гэсэн 8 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж 13 тогтоол гаргасан.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2019 оны 12-р сарын 25-ны өдрийн 227 дугаар зарлигаар эрхэлсэн ажилдаа олон жил үр бүтээлтэй ажилласан иргэдийг Монгол Улсын цол, одон медалиар шагнасныг УИХ-ын гишүүн, БСШУС-ын сайд Ё.Баатарбилэг болон аймгийн удирдлагууд 12-р сарын 29-ний өдөр гардуулсан байна.

Энэ үеэр Хөдөлмөрийн гавъяаны улаан тугийн одонгоор 7, “Алтан гадас” одонгоор 23, “Хөдөлмөрийн хүндэт” медалиар 19 хүн, нийт 50 хүн шагнагдсан байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны мэдээлэл

Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 3.011.6 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 25 төсөл, арга хэмжээ хэрэгжихээр батлагдаж 2019 онд онд 3.011.6 сая төгрөгөөр санхүүжүүлэхээс 2019 оны жилийн эцсийн байдлаар зарцуулалт нь 2.499.3 сая төгрөг, 19 сумын орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалт 1.674.2 сая төгрөг байна.

Аймгийн авто замын сангийн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээнд 275.7 сая төгрөг батлагдсанаас 2019 оны жилийн эцсийн байдлаар 275.7 сая төгрөгийг зарцуулсан байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 3 төсөл арга хэмжээнд 132.7 сая төгрөг үүнээс барилга байгууламж 120.0 сая төгрөг, тоног төхөөрөмж 12.7 сая төгрөг тус тус тусгагдсанаас 2019 оны жилийн эцсийн байдлаар зарцуулалт нь 12.7 сая төгрөг байна.

Аймгийн удирдах ажилтны 9 дэх удаагийн буюу 2019 оны сүүлчийн шуурхай зөвлөгөөнийг 2019 оны 12-р сарын 25-ны өдрийн 09.00 цагт аймгийн ЗДТГ-ын VIP танхимд зохион байгуулж зөвлөгөөнд 51 удирдах албан тушаалтан оролцохоос 38 албан тушаалтан оролцож ирц 74.5 хувь байв.

Энэ удаагийн шуурхай зөвлөгөөнөөр аймгийн удирдлагуудаас сум, байгууллагын дарга нарт үүрэг даалгавар өгөөгүй бөгөөд 2019 онд зохион

байгуулсан шуурхай зөвлөгөөнүүдийн үүрэг даалгаврын биелэлтийн явц, үр дүн, удирдах ажилтнуудын ирц, оролцоо болон цаашид эрчимжүүлэх шаардлагатай цаг үеийн ажил арга хэмжээний талаар хэлэлцсэн байна.

12-р сарын 4-ний өдөр аймгийн Засаг даргын Тамгын газраас сумдын Засаг дарга болон төсөвт байгууллагуудын удирдлагуудтай 2 дахь удаагийн онлайн хурлыг зохион байгууллаа.

Онлайн хуралд нийт 18 сумын 108 албан хаагч оролцохоос 100 оролцож, 95 хувийн ирцтэй байв. Хурлаар цаг үеийн шинж чанартай мэдээ мэдээлэл, анхаарах асуудлуудыг танилцуулж, сумдаас тавьсан асуултад хариулт өгсөн байна.

Аймгийн ЗДТГ-аас Засгийн газрын 2019 оны 37,38 дугаар тогтоол, ЗГХЭГ-ын даргын 2019 оны 47 дугаар тушаалаар баталсан байгууллага, нэгж, төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, тайлагнах, үнэлэх журам сэдвээр 2019 оны 12-р сарын 18-ны өдөр сумдын ЗДТГ-ын дарга, нутгийн захиргаа, эрх зүйн ажилтнуудад, архив, бичиг хэргийн эрхлэгч нарт албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгийн дүн, цаашид анхаарах асуудлаар, 12-р сарын 20-ны өдөр аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагийн хүний нөөц, хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан албан хаагчдад тус тус сургалт зохион байнуулж агентлагаас 33, сумдаас 50, нийт 83 албан хаагчийг хамруулаа.

Аймгийн Онцгой комисс 12-р сарын 25-ны өдөр хуралдаж аймгийн хэмжээнд томуу, томуу төст өвчний нөхцөл байдал, цаг уур, өвөлжилтийн нөхцөл байдал, Засгийн газрын 2019 оны 419 дүгээр /Мал өвөлжилтийн талаар авах зарим арга хэмжээний тухай/ тогтоолоор олгосон хөрөнгийн зарцуулалтын талаар хэлэлцэж томуугийн В вирусын дэгдэлт цэцэрлэгийн насны хүүхдүүдийн дунд их байгаатай холбогдуулан аймгийн хэмжээний хүүхдийн цэцэрлэгүүдийн үйл ажиллагааг 2019 оны 12-р сарын 26-наас 2020 оны 01 дүгээр сарын 13-ныг хүртэл түр зогсоох шийдвэр гаргасан.

Мөн өвөлжилт хүндэрч болзошгүй байгаа зарим сумын малчид, иргэдэд эрүүл мэндийн болон төрийн үйлчилгээг үзүүлэх отрын штаб байгуулах, отроор яваа иргэдэд тусламж үйлчилгээ үзүүлэхээр шийдвэрлэлээ.

Төрийн албаны тухай хуулийн 36 дугаар зүйл болон Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1995 оны 109 дүгээр зарлигаар баталсан “Төрийн захиргааны албан хаагчийн тангараг өргөх ёслолын журам”-ын дагуу төрийн захиргааны албанд анх удаа орж байгаа албан хаагчдын тангараг өргөх ёслолын арга хэмжээг 12-р сарын 25-ны өдөр аймгийн ЗДТГ-т зохион байгууллаа. Энэ үеэр агентлаг, сумдын 16 албан хаагч тангараг өргөсөн байна.

2019 оны аймгийн шилдэг төрийн албан хаагч, аж ахуйн нэгж, бизнес эрхлэгчдэд шагнал гардуулах ёслолын арга хэмжээг 12-р сарын 25-ны өдөр аймгийн ЗДТГ-т зохион байгуулж шилдэг төрийн албан хаагчдыг төрийн алба, хууль зүй, банк санхүү, эрүүл мэнд, боловсрол, соёл урлаг, спорт, үйлчилгээ номинациар; шилдэг аж ахуйн нэгж, бизнес эрхлэгчдийг үйлчилгээний байгууллага, жижиг дунд үйлдвэр эрхлэгч, компанийн нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэгч, байгаль орчин ногоон хөгжилд ээлтэй байгууллага, хамгийн олон ажлын байр бий болгогч, орон нутгийн брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, шинэ санаа, шилдэг ноу-хау, бүтээн байгуулалт, татвар төлөгч, шилдгийн шилдэг номинациар тус тус шалгаруулж шагнал гардууллаа.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 5-р сарын 16-ны өдрийн 24 дүгээр тогтоолоор баталсан "Багийн хөгжил” аймгийн дэд

хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 101 багийн Засаг дарга нарын дунд зарласан болзолт уралдаанд амжилттай оролцож, 2019 оны ажил үйлсээрээ манлайлсан, шилдэг 5 багийн Засаг даргыг шалгаруулж, өргөмжлөл, мөнгөн шагнал, явуулын тоног төхөөрөмжийг гардуулсан байна.

Хоёр. Эдийн засаг, төсөв, санхүүгийн бодлогын хүрээнд

Татвар төлөлтийн талаар

2019 оны 12-р сард улсын төсөвт 257.2 сая төгрөг төвлөрүүлэхээс 257.2 сая төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөг 100 хувиар, орон нутгийн төсөвт 1,006.8 сая төгрөг төвлөрүүлэхээс хүлээгдэж буй гүйцэтгэлээр 1,006.8 сая төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөг 100 хувь биелүүлэхээр байна.

Тайлант хугацаанд 11-р сарын нэмэгдсэн өртгийн албан татварын 219 тайлан цахимаар хүлээн авч тайлангийн ирцийг 99.5 хувьтай хангуулж, шалгуур үзүүлэлт хангаагүй байцаагчид хуваарилагдсан 22 тайланг тайлан хүлээн авах журмын дагуу хүлээн авч баталгаажууллаа.

Өмч, худалдан авах ажиллагааны чиглэлээр

Орон нутгийн өмчит 188 төсөвт байгууллагад 958.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авах, 30 төсөвт байгууллагад 1031 нэрийн 392.5 сая төгрөгийн өртөг бүхий үндсэн хөрөнгө данснаас хасах зөвшөөрлийг тус тус олгосон байна.

Гурав. Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд

Улсын бүртгэлийн чиглэлээр

2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар иргэний бүртгэлийн чиглэлээр 1776 бүртгэл хийж гүйцэтгэлээ.

Иргэний бүртгэлийн чиглэлээр:

- Шинээр төрсөн хүүхдээ бүртгүүлсэн төрөлт – 221
- Гэрлэлтийн бүртгэл -39
- Гэрлэлт цуцалсаны бүртгэл - 4
- Хүүхэд үрчлэлтийн бүртгэл – 5
- Эцэг тогтоосны бүртгэл- 4
- Овог эцэг /эх/-ийн нэр, нэр өөрчилсөний бүртгэл - 5
- Нас баралтын бүртгэл - 54
- Шинээр иргэний үнэмлэх олгосон - 108
- Дахин олгосон - 86
- Иргэний үнэмлэхний хугацаа дуусч солиулсан – 261
- Үндэсний энгийн гадаад паспорт- 93
- Шилжилт хөдөлгөөн – 392
- Иргэнд - 448 лавлагаа
- Хууль хяналтын байгууллагад - 56 лавлагаа

Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн чиглэлээр:

2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар нийт эд хөрөнгийн эрхийн бүртгэл, хуулийн этгээдийн бүртгэл 456 мэдүүлгийг хүлээн авч дараах бүртгэлийг хийж гүйцэтгэлээ.

- Газар өмчлөх эрхийн анхны бүртгэл – 44
- Үл хөдлөх хөрөнгө өмчлөх эрхийн анхны бүртгэл - 16

- Шинээр бүртгүүлсэн орон сууцны бүртгэл – 20
- Газар эзэмших эрхийн анхны бүртгэл – 16
- Арилжааны гэрээ –
- Худалдах худалдан авах гэрээ – 27
- Бэлэглэлийн гэрээ – 10
- Барьцааны эрхийн бүртгэл – 284
- Өв залгамжлал – 7
- Хамтран өмчлөгч өөрчлөгдөх – 6
- Лавлагаа – 5
- Бусад эрхийн бүртгэл – 15

Хууль хяналтын байгууллагад 50 лавлагааг гарган хүргүүлсэн байна. Дээрх бүртгэлүүдийг хийж улсын төсөвт үйлчилгээний хөлс 4488854 тэмдэгтийн хураамжид 197032 төгрөг, үл хөдлөх хөрөнгө худалдсанаас оруулсан татварын орлого 5551312 төгрөг төвлөрүүлсэн байна.

Хуулийн этгээдийн чиглэлээр

- Шинэ-8
- Өөрчлөлт-4
- Тамга тэмдэгтийн хяналтын дугаар олгосон - 8

Шүүхийн шинжилгээний албанаас 12-р сард криминалистикийн шинжилгээ 1, хэргийн газрын үзлэгээр илрүүлж бэхжүүлсэн ул мөр, эд мөрийн баримт 27, шүүх эмнэлгийн шинжилгээ 16, тусгай шинжилгээ 9-г тус тус хийсэн байна.

Аймгийн хэмжээнд 12-р сард объектын гал түймрийн дуудлага 1, галын зөрчил 3, мал амьтны гоц халдварт өвчин 1, техникийн холбогдолтой ослын мэдээлэл 2 удаа тус тус ирсэн байна.

Онцгой байдлын ерөнхий газрын даргын баталсан удирдамжийн хүрээнд аймгийн Онцгой байдлын газраас 12 дугаар сарын 15-30-ны өдрүүдэд шинэ жилийн баяр тэмдэглэх, хүлээн авалт зохион байгуулах ресторан, караоке, баар, зочид буудал, үзвэр үйлчилгээ, соёл урлагийн байгууллагууд, томоохон худалдааны төв, зах болон нийтийн эзэмшлийн талбайд шинэ жилийн тоглоом, хэрэгсэл худалдаалж буй иргэд болон пиротехникийн хэрэгслийг импортлох, хадгалах, ашиглах зөвшөөрөлтэй барилга байгууламжуудад төлөвлөгөөт бус хяналт шалгалт зохион байгуулж хяналт тавьж ажиллалаа.

2019 онд аймгийн хэмжээнд 584 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 91 хэргээр буюу 15.8 хувиар өссөн байна.

Нийт 2016 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас гэмт хэргийн шинжтэй 875 буюу 43.4%, зөрчлийн шинжтэй 1141 буюу 56.6 хувийг эзэлж байна. Хүлээн авсан гомдол мэдээллийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 478 буюу 23.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Нийт шалгасан 875 гомдол мэдээллийн 865 буюу 98.8 хувийг 5 хоногт хуульд заасан журмын дагуу шалган шийдвэрлэсэн байна.

Архангай аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт 2201464.7 төгрөгийн мөнгөн дүн бүхий 603 гүйцэтгэх баримт бичиг ирснээс шийдвэр гүйцэтгэх бодит биелэлтийн хувь 57, мөнгөн дүнгийн дундаж үзүүлэлт 32.9 байна.

Дөрөв. Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд

Боловсролын чиглэлээр

“Багшийн хөгжил” аймгийн дэд хөтөлбөрийн хүрээнд аймгийн ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэгүүдийн багш нарын дунд “Бүтээлч багш”-2019 уралдааныг 11-р сарын 28-30-ны өдрүүдэд сургуулийн өмнөх боловсрол, бага боловсрол, байгалийн ухаан, нийгмийн ухаан, хүмүүнлэгийн ухаан, орос хэлний багш гэсэн зургаан чиглэлээр зохион байгуулсан байна. энэхүү уралдаанд 20 сургууль, 28 цэцэрлэгээс шалгарсан нийт 134 багш оролцсон.

Засгийн газрын 2019 оны 200 дугаар тогтоолоор баталсан Хүүхэд, залуучуудад цэрэг, эх оронч үзэл төлөвшүүлэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд цэрэг эх оронч үзэл төлөвшүүлэх сургалт, хүмүүжлийн үйл ажиллагааг 2019 оны 12-р сарын 23-ны өдөр аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб, Боловсрол, соёл урлагийн газар, Хөгжимт драмын театр хамтран зохион байгуулсан бөгөөд Эрдэнэбулган сумын 5 ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн 250 сурагч оролцсон байна.

Соёл урлагийн чиглэлээр

Аймгийн Нийтийн номын сан нийтийн уншлагын танхимаар 15 уншигч шинээр бүртгэж, 150 ирэгсэдэд 255 ном, 70 сонин, сэтгүүлээр, хүүхдийн уншлагын танхимаар шинээр 14 уншигч бүртгэж, 1059 ирэгсэдэд 1310 номоор, гэрээр ном олгох үйлчилгээгээр 4 уншигч шинээр бүртгэж 88 ирэгсэдэд 176 ном, 45 сонин хэвлэл, зөөврийн номын сангийн үйлчилгээгээр 23 байгууллагад үйлчилж 38 уншигч шинээр бүртгэж, 140 ирэгсэдэд, 339 номоор тус тус үйлчилсэн байна.

Аймгийн Хөгжимт драмын театр 12-р сарын 5, 6, 7-ны өдрүүдэд **“**Өвөл цагийн нээлт” шинэ уран бүтээлийн тоглолтоо зохион байгуулж нийт 500 гаруй үзэгчдэд толилуулсан байна.

Мөн 12-р сарын 8-ны өдөр Төрийн шагналт С.Соронзонболдын хөгжим “Зая гэгээнтэн” түүхэн дуулалт жүжгээр “Гэгээн муза-15” олон улсын наадмын нэгдүгээр шатны шалгаруулалтанд оролцсон.

Эрүүл мэндийн чиглэлээр

Аймгийн хэмжээнд 2019 оны 11 сарын байдлаар нийт 26116 үзлэг хийгдсэнээс бодит тоогоор 9655 буюу 37.0 хувийг урьдчилан сэргийлэх үзлэг эзэлж байна.

2019 оны 11 сарын байдлаар 160 эх төрсөн нь өнгөрсөн оны мөн үеэс 28 тохиолдолоор нэмэгдсэн байна.

Нийт төрөлтийн 82.1 хувь нь аймгийн Нэгдсэн эмнэлэгт, 11.3 хувь нь сумын Эрүүл мэндийн төвүүдэд, 6.8 хувь нь Сум дундын эмнэлэгт тус тус төрсөн байна.

Хүн амын нас баралтын 43 тохиолдол бүртгэгдсэн. Нас баралтын тэргүүлэх шалтгаанд цусны эрхтэн тогтолцооны өвчлөлийн нас баралт 12, хорт хавдарын нас баралт 11, осол гэмтэл, гадны шалтгаант нас баралт 12 тохиолдлоор тэргүүлж байна.

Өмнөх оны энэ үетэй харьцуулахад нийт нас баралт 7 тохиолдлоор, осол гэмтэл, гадны шалтгаант нас баралт 4 тохиолдолоор нэмэгдсэн.

Нийт тохиолдлын 86.0 хувь нь гэртээ, 13.9 хувь нь эмнэлэгт нас барсан бөгөөд үүнээс хоног болоогүй нас баралт 66.6 хувийг эзэлж байна.

0-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 4 тохиолдол, үүнээс 1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 4 тохиолдол, эрт нярайн эндэгдэл 2 тохиолдол байна. Аймгийн

хэмжээнд эхний 11 сарын байдлаар халдварт өвчний нийт 30 тохиолдол бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 23 тохиолдолоор буурсан.

Цочмог халдварт өвчин 9 тохиолдол бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс 27 тохиолдлоор буурсан хэдий ч архаг халдвар өвчин 21 тохиолдол бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс 4 тохиолдлоор нэмэгдсэн байна.

Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын чиглэлээр

2019 оны 12 сарын байдлаар Хөдөлмөрийн зах зээлийн нэгдсэн сан LMIS программд ажил идэвхитэй хайгч 1428 иргэн бүртгэлтэй байгаагаас 708 эмэгтэй, ажил олгогч байгууллагуудаас ирүүлсэн ажлын байрны захиалга 1015, зуучлал 970 байна. Тухайн сарын 20-ны байдлаар 164 иргэн нь шинээр бүртгүүлж, LMIS программд шивж оруулсан. Ажил идэвхитэй хайгч иргэдийг боловсролын түвшингээр ангилвал: боловсролгүй- 15, бага-59, суурь-215, бүрэн дунд-899, техникийн болон мэргэжлийн анхан шатны – 34, тусгай мэргэжлийн дунд-22, Дипломын бакалаврын-194, магистр-1 иргэнийг тус тус бүртгэж мэдээллийн бааз үүсгэн ажилласан байна.

Байнгын шинэ ажлын байр 1030, улирлын ажлын байр 55, түр ажлын байр 417 нийт 1502 ажлын байр бий болсон байна. Шинэ ажлын байрыг эдийн засгийн салбараар нь ангилвал: Хөдөө аж ахуйн салбарт 382, боловсруулах үйлдвэрлэлд 425, Бөөний болон жижиглэнгийн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээний салбарт 59, бусад салбарт 636 ажлын байр шинээр бий болсон байна. Ажлын байранд зуучлагдан орсон иргэдийг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар ангилвал: Хөдөө аж ахуйн салбарт 322, боловсруулах үйлдвэрлэлд 30, барилга 136, үйлчилгээний болон бусад салбаруудад 482 иргэн зуучлагдан орсон байна.

Нийгмийн даатгалын санд 2019 оны 12 дугаар сарын байдлаар нийт 16,4 тэрбум төгрөгийн шимтгэлийн орлого төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 110 хувиар биелүүлсэн байна. Давхардсан тоогоор 16,0 мянган иргэний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн зардалд нийт 49.20 тэрбум төгрөг зарцуулжээ. Улсын төсвөөс 1995 оноос өмнө тэтгэвэр тогтоолгосон иргэдийн болон цэргийн тэтгэвэрт 51,333 сая төгрөгийг нийгмийн даатгалын санд шилжүүлжээ.

Нийгмийн даатгалын санд 2019 онд 16,8 тэрбум төгрөгийн сангийн орлого төвлөрүүлсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2,6 тэр бум төгрөгөөр өссөн.

Ажил олгогч, даатгуулагчаас төлсөн шимтгэлийн орлогыг дараах байдлаар нийгмийн даатгалын сангуудад хуваарилсан байна. Үүнд:

- Тэтгэврийн даатгалын санд 90,3% буюу 51180.9 сая төгрөг
- Тэтгэмжийн даатгалын санд 2,9 % буюу 1624.7 сая төгрөг;
- ҮОМШӨ-ний даатгалын санд 1,3% буюу 717.2 сая төгрөг;
- Ажилгүйдлийн даатгалын санд 0,4% буюу 252.3 сая төгрөг;
- Эрүүл мэндийн даатгалын санд 5% буюу 2852.8 сая төгрөг

2019 оны нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, тусламж, үйлчилгээний зардалд нийт 49.20 тэрбум төгрөг зарцуулжээ. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад сангийн зардал 4,4 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Тухайн сард тэтгэврийн даатгалын санд 51180 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлж, улсын төсвөөс 350,0 сая төгрөгийг тэтгэврийн даатгалын санд хүлээн авсан. Тус сангаас өндөр насны, тахир дутуугийн, тэжээгчээ алдсаны, цэргийн тэтгэвэр авагч 13.4 мянган иргэдийн тэтгэвэрт 47,43 тэрбум төгрөг зарцуулжээ.

Нийт 78,7 хувь буюу 37,2 тэрбум төгрөгийг өндөр насны тэтгэвэр авагч 10,3 мянган иргэнд зарцуулсан байна.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн чиглэлээр

2019 оны шилдэг гэр бүл, хүүхэд, залуучуудыг шалгаруулан, шагнал гардуулдаг "ГОО ДАЛЬ-2019" арга хэмжээг 2019 оны 12-р сарын 27-ны өдөр зохион байгуулж оны шилдэг хүүхдийг "Сурлагын амжилт", "Техник сэтгэлгээ, шинийг сэдэх санал, санаачлага", "Биеийн тамир, спорт", "урлаг, уран бүтээл", "эх орны түүх, соёл, өв уламжлал", "Хүүхдийн өөрийн удирдлагын байгууллага", "Байгаль хамгаалал эрүүл аюулгүй орчин", "Хүмүүнлэг, энэрэнгүй үйлс", "Багийн амжилт" гэсэн 9 номинациар, оны шилэг залууг "Шилдэг залуу малчин", "Шилдэг залуу багш", "Шилдэг залуу эмч" "Спортын салбарын шилдэг залуу", "Хүмүүнлэгийн үйлс бүтээсэн шилдэг залуу", "Төрийн албаны шилдэг залуу", "Төрийн үйлчилгээний шилдэг залуу" гэсэн 9 номинациар, оны шилдэг бүлийг "Бүтээлч гэр бүл", "Авъяаслаг гэр бүл", "Спортлог гэр бүл", "Оюунлаг гэр бүл", "Эко гэр бүл", "Малчин гэр бүл" гэсэн номинациар тус тус шалгаруулан шагна гардуулсан байна.

Мөн "Хүүхдэд ээлтэй байгууллага", "Хүүхдэд ээлтэй цэцэрлэг", "Хүүхдэд ээлтэй сургууль", "Хүүхдэд ээлтэй дотуур байр", "Хүүхдэд ээлтэй Эрүүл мэндийн төв", "Хүүхдэд ээлтэй сум", "Шилдэг хамтарсан баг", "Шилдэг хүүхдийн элч", "Гэр бүлийг дэмжигч байгууллага" номинацийн эздийг тодруулсан.

Тав. Хөдөө аж ахуйн бодлогын хүрээнд

Мал аж ахуй

Аймгийн хэмжээнд 2019 онд 17.3 мянган малчин, мал бүхий өрхийн 52.8 мянган малчин урьдчилсан тооцоогоор 6157.6 мянган толгой мал үүнээс тэмээ 1.3 мянга, адуу 425.0 мянга, үхэр 709.0 мянга, хонь 3317.1 мянга, ямаа 1705.2 мянган толгой тоологдсон байна. Малын тоо толгойг өмнөх онтой харьцуулахад 12.3 хувь буюу 675.6 мянган толгойгоор өссөн.

2019 онд аймгийн хэмжээнд 11 сумын 28.3 мянган толгой малыг үзлэг ангилалтад хамруулж анги чанарыг тогтоон цөм сүрэг бүрдүүлсэн. Аймгийн хэмжээнд цөм сүргийн малын тоо 590.6 мянгад хүрч нийт мал сүргийн 10.7 хувийг эзэлж байна.

Хөдөөгийн хүн ам, мал сүргийг усаар хангах, бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор 2019 онд аймгийн хэмжээнд сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө, гадаадын төсөл хөтөлбөр болон малчдын хөрөнгөөр 22 инженерийн хийцтэй гүн өрмийн худгийг шинээр гаргаж 3 худгийг засварлан нийт 25 худгийг ашиглалтанд оруулж 230 гаруй өрхийн 50.0 гаруй мянган толгой мал, 29.8 мянган га бэлчээрийг усжуулсан байна. Нийт малчин өхийн 60 орчим хувь нь усаар хангагдсан бусад өрхүүд худаг уст цэгээс алслагдсан байдалтай өвөлжиж байна.

Аймгийн хэмжээнд малчид 76.3 мянган тн өвс, 1287 тн гар тэжээл, 190 тн сүрэл, 1554 тн ногоон тэжээл, 877 тн үйлдвэрийн тэжээл, 1639 тн давс хужир шүү бэлтгэн авснаас одоогийн байдлаар 40 орчим хувийг нь зарцуулаад байна.

Аймаг, сумдын аюулгүйн нөөцөд 2350 тн байгалийн хадлан, 670 тн тэжээл бүрдүүлэхээс 1244.5 тн өвс, 486.5 тн тэжээл төвлөрүүлсэн нь 57.0 хувьтай байна.

Одоогоор сумдын аюулгүй нөөцийн 30 орчим хувийг малчдад хямдралтай үнээр нийлүүлсэн байна.

Зургаа. Байгаль орчин, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийн салбарын бодлогын хүрээнд

Байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлээр

БОАЖЯ-наас 11-р сарын 29-30, 12 дугаар сарын 1-ний өдрүүдэд “Мишээл” экспод нөхөрлөлүүдийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор “Экологид ээлтэй бүтээгдэхүүн-2019” үзэсгэлэн худалдааг Нөхөрлөлүүдийн үндэсний холбоотой хамтран зохион байгуулжээ.

Энэхүү үзэсгэлэн худалдаанд 21 аймгийн 254 нөхөрлөлийн 390 гаруй төлөөлөл, Архангай аймгийн 8 сумын 21 нөхөрлөлийн 45 төлөөлөл оролцсоноос Жаргалант сумын "Баян-Өндөр" ойн нөхөрлөлийн сийлбэртэй модон бүтээгдэхүүн тусгай байранд, Булган сумын "Могойнхон" ойн нөхөрлөлийн бүтээгдэхүүнүүд II байранд тус тус шалгарсан байна.

Архангай аймгаас оролцсон нөхөрлөлүүд “Экологид ээлтэй бүтээгдэхүүн-2019” үзэсгэлэнгийн үеэр 2 тонн гаруй цагаан идээ, 800 орчим гар урлалын бүтээгдэхүүнийг 28 сая төгрөгөөр борлуулсан байна.

Газар, барилга, дэд бүтцийн чиглэлээр

2019 онд аймгийн хэмжээнд газрын төлбөр 60000,0 мянган төгрөг орохоос 72712,6 мянган төгрөг, Газрын дуудлага худалдаагаас 271873,1 мянган төгрөг орохоос 289564,7 мянган төгрөг орж төлөвлөгөөг давуулан биелүүлсэн байна.